

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Авлигатай тэмцэх газар 2016 онд дэвшүүлсэн зорилт, жил, улирлын төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд тайлант онд хийсэн ажил, хүрсэн үр дүнгийн талаар тайлагнаж байна.

Нэг. Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой 133 байгууллага “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” батлан ирүүлсэн бөгөөд хөндлөнгийн “Шинжээчдийн баг”-уудаас төрийн байгууллагын авлигын эсрэг 2015 оны үйл ажиллагааг үнэлсэн тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу 2016 онд хэрэгжүүлсэн ажлын талаар төрийн 124 байгууллагад, авлига, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулиар хүлээсэн үүргээ шударгаар гүйцэтгэж ажиллах талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус зөвлөмж боловсруулж хүргүүлэв.

Улсын Их Хурлаас байгуулагддаг болон ажлаа тайлагнадаг байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны үр дүнг хэлэлцэх уулзалтыг УИХ-ын Тамгын газартай хамтран зохион байгуулав. Төрийн байгууллагуудын 2016 оны авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх “Шинжээчдийн баг”-ийг сонгон шалгаруулж гэрээг байгуулав. Үнэлгээнд Улсын Их Хурлаас байгуулагддаг 7 байгууллага, 13 яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч 23 агентлаг, аймаг, нийслэл 22, нийслэлийн 9 дүүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 53 хуулийн этгээд, нийт 127 байгууллага хамрагдаж, улсын дундаж үнэлгээ 61,7%-тай үнэлэгдсэн байна.

Төрийн байгууллагуудын “Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэхэд баримтлах шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулж, Газрын даргын 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/54 тоот тушаалаар батлуулав.

Төрийн 47 байгууллагын цахим хуудсанд явцын үнэлгээ хийн хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад заавар зөвлөгөө өгч, дэмжлэг туслалцаа үзүүлж, арга зүйн удирдлагаар ханган ажиллав.

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2-т заасныг хэрэгжүүлэх хүрээнд “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм журмыг хянах заавар”-ын болон “Авлигын эрсдлийг үнэлэх аргачлал”-ын төслийг тус тус боловсруулав.

Гадаад хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн яам, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Уул уурхай яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Дундговь аймаг, Батлан хамгаалах яамны зэвсэгт хүчний хөгжлийн сан, Нийслэлийн Эрүүл мэндийн нэгдэл, Улаанбаатар хотын гаалийн газар, Дорнод, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Замын-Үүд дахь гаалийн газар, Автотээврийн үндэсний төв ТӨК-ийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар заавар, зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах, хууль сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр ажиллалаа.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг нь дээшлүүлэх, энэ чиглэлээр зөвлөх, арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр удирдамж боловсруулан батлуулж барилга, уул уурхай салбар, гааль салбар, эрүүл мэнд, боловсролын салбарт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд салбаруудад ажилласан байна.

2016 онд Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 6 зөвлөмж хүргүүлж, 1 дүрэм, 9 журам, 3 захирамж, 9 тогтоол, 2 тушаал хүчингүй болгуулж, 5 ёс зүйн дүрмийн төсөлд санал өгсөн байна.

“Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулав. “Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулах нь-асуудал ба шийдэл” сэдэвт илтгэлийн уралдааныг зарлан, зохион байгуулж, шилдэг илтгэлийг шалгаруулж дүгнэв. “Авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоо” сэдэвт нийслэлийн их, дээд сургуулиудын аварга шалгаруулах парламентийн мэтгэлцээн тэмцээнийг “Монголын мэтгэлцээний нэгдсэн танхим”-тай хамтран амжилттай зохион байгуулав.

Мөрдөн байцаагчийн мэдэгдэл, зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийн мөрөөр Зам тээврийн яам, Зам тээврийн хөгжлийн төв, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн боловсролын газар, Хүнс хөдөө аж ахуйн яаманд тус тус ажилласан.

Олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр 236 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 14300 хүнийг сургалтад хамруулжээ.

Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомжийг сурталчилах чиглэлээр сургалт явуулах “Сургагч багш бэлтгэх журам”-ын төслийг боловсруулав.

“Авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэл”-ийн төслийг бэлтгэж 500 хувиар, “Туулай хүүгийн адал явдал” номыг дахин хэвлүүлэв. Авлигын эсрэг хууль тогтоомжийг олон нийтэд энгийн ойлгомжтой байдлаар хүргэх, анимейшн бүтээх ажлын хүрээнд гүйцэтгэгч “Нью медиа” групптэй хамтран 1-16 дугаар ангийг бүтээлгэв. Сонгуулийн хандив, улс төрийн намын санхүүжилтийн асуудлаар хийсэн 2 анги болон 8 богино хувилбарыг Сонгуулийн ерөнхий хороотой хамтран нийслэл орон нутгийн телевиз, төрийн бус байгууллагуудыг цахим хуудсаар түгээв. Глоб интернешнл төв ТББ-аас оюутан сурагчдад авлигын эсрэг ойлголт, мэдлэг олгох кино сургалтын модуль боловсруулах ажлын хэсгийн уулзалтад оролцож “Хангай ба түүний нөхөд: Урвагч” цувралаар сургалт хийх бэлтгэл хангах, сургалтын модуль боловсруулах ажлын хэсгийг арга зүйн удирдлагаар ханган оюутнуудад сургалт хийж, гарын авлагаар хангаж дэмжлэг үзүүлэв. “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” сургалтыг тогтмол зохион байгуулж **153** хүн хамрагдсан байна. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газартай “Авлигагүй Сүхбаатар дүүрэг” сэдэвт дэвжээ тэмцээнийг хамтран зохион байгуулав.

Замын-Үүд дэх Гаалийн газар, Дорнод аймгийн Гаалийн газрын болон Баянхошуу, Хавирга боомтууд, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газарт 650 гаруй албан тушаалтанд авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалт зохион байгуулав.

2016 онд нийт 14 төрлийн 8015 ширхэг гарын авлага, тараах материалыг төрийн 48 байгууллагад, үүнээс 3299 ширхэгийг 21 аймагт, 845 ширхэгийг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд, оюутан залууст, 3871 төрийн төв, нийслэлийн засаг захиргааны байгууллагад тус тус түгээжээ.

Авлигын эсрэг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаас хийж байгаа үйл ажиллагаа, мэдээ, мэдээлллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Хамтдаа.мон” цахим хуудсыг шинэчлэх ажлыг Азийн сантай хамтран зохион байгуулж, цахим хуудасны нээлтийг 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөр хийв.

Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр Их Британийн стандартчлалын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын удирдлагатай, Азийн сан, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, Нийслэлийн худалдаа аж, үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн холбооны төлөөлөлтэй, УИХ-ын дэргэдэх “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагаа төсөл”-ийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулж санал солилцов.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Удирдах зөвлөлийн хуралд оролцож, уг Монгол Улсын авлигын эсрэг үйл ажиллагааны явцын тайланг бэлтгэх ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны талаар болон шүүх байгууллагатай холбоотой асуултуудын дагуу холбогдох тайланг хэлэлцүүлэн үнэлүүлсэн. “Эдийн засаг, байгаль орчны салбарын хэрэгжилт” зөвлөгөөнд “Бизнес болон эдийн засгийн хөгжлийн урьдчилсан нөхцөл болох авлигатай тэмцэх, эрх зүйт ёсыг бэхжүүлэх нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

Шударга байдлын үнэлгээний 2015 оны судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдамжаар ханган ажиллав. Тус судалгаанд 62 байгууллагаас төрийн үйлчилгээ авсан 2370 иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, 1410 төрийн албан хаагч, 630 шинжээчээс цуглуулсан мэдээллийг гүйцэтгэгч компаниас хүлээн авч, судалгааны тооцооллыг хийж үр дүнг гаргаж, тайланг боловсруулж, хэвлүүлэв.

Шударга байдлын үнэлгээний аргачлал, арга зүй болон 2015 оны үр дүнг яам, агентлагийн төлөөлөл 15 яам, 25 агентлагийн төлөөллийг оролцуулан танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Үнэлгээгээр хангалтгүй үзүүлэлттэй гарсан байгууллагын тоон мэдээлэлд үндэслэн танилцуулга бэлтгэх ажлын хүрээнд боловсролын салбар дахь авлигын нөхцөл байдал болон тус салбар дахь авлигатай тэмцэхэд анхаарах асуудлын талаар танилцуулга бэлтгэв.

Судалгааны мэдээллийг 4900 орчим нэгжээс цуглуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнгийн тооцоолол хийх ажлыг эхлүүлээд байна.

Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолын дагуу Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2015 оны судалгааг зохион байгуулах ажлын хүрээнд шинжээчдээс мэдээлэл цуглуулах ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэн хүлээн авч, судалгааны тооцооллыг хийн үр дүнг гаргаж, тайланг бэлтгэн холбогдох талуудад хүргэхийн зэрэгцээ, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллав.

Хүүхдийн шударга байдлын үнэлгээг тогтоох зорилгоор судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран зохион байгуулав. Судалгаанд Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангийн 1929 сурагчдыг хамруулсан байна. Улмаар судалгааны тооцооллыг хийж, зөвлөмж бүхий тайланг бэлтгэн “Хүүхдийн шударга байдал-2015” судалгааны үр дүнг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Хүүхдийн шударга байдал”-ын 2016 оны судалгааны мэдээллийг цуглуулах ажлыг онлайн хэлбэрээр цуглуулах ажлыг эхлүүлсэн.

ЦЕГ-тай хамтран “Авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй цагдаагийн байгууллагын ажлын байр, албан тушаалыг тодорхойлох судалгаа”-нд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллав. Мөн ШШГЕГ-тай хамтран зохион байгуулсан “Авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаалыг тодорхойлох судалгаа”-ны асуулгыг боловсруулан ШШГЕГ-ын 400 албан тушаалтныг хамруулан мэдээлэл цуглуулав. Мэдээллийг боловсруулан дүн шинжилгээ хийж байна.

Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хотын гаалийн газарт ажиллах ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу Эрсдэлтэй ажлын байр, албан тушаалын судалгааны хүрээнд асуулгыг бэлтгэн, мэдээлэл цуглуулах онлайн программд оруулж гаалийн албан тушаалтнуудаас судалгааг авах, холбогдох хэлтсийн ажилтнуудтай ярилцлага, чанарын судалгаа хийх зэргээр ажиллав. Эрсдэлтэй ажлын байр, албан тушаалын судалгааны тайланг бэлтгэв.

Дээр дурдсан судалгаануудын үр дүнг олон нийтэд хүргэх чиглэлээр тусгайлсан мэдээллийг салбар, чиглэлээр бэлтгэн боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ярилцлага өгч, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, цахим хуудсаар түгээлээ.

“АТГ-т хүлээн авсан гомдол, мэдээлэл, тэдгээрийн шийдвэрлэсэн байдлын шинжилгээ, гомдол мэдээлэлд дурдсан нөхцөл байдалд үндэслэн авлигын гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийн шинжилгээ хийх” ажлын хүрээнд 2015 оны 12 дугаар сар болон 2016 оны 1-10 дугаар саруудад АТГ-т хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, байгууллагын цахим хуудсанд байршуулан, шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэсэн.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн 2012-2016-ны 5 дугаар сар хүртэлх тоон мэдээлэл, Нийтийн албан тушаалтны албан үүрэгтэй нь холбогдолгүйгээр авсан бэлгийн талаарх 2013-2015 оны мэдээлэл, Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрлэлтэд, төрийн байгууллагаас дарамт шахалт үзүүлсэн, хүнд суртал гаргасан, ёс зүй зөрчсөн талаар 2014-2016 оны 8 дугаар сард иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд судалгаа дүн шинжилгээ хийв.

Хоёр. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын чиглэлээр:

2016 оны бүрдүүлэлтийн үйл ажиллагааны хүрээнд гарах эрсдлийг тооцож түүнээс гарах арга хэмжээг авч ажилласан бөгөөд хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянах ажлыг хариуцаж байгаа төв, орон нутгийн 109 байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд болон салбар ЭБАТ-д мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, тэдний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мөн мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлын явц байдал, нэгдсэн дүнгийн талаарх мэдээллийг газрын цахим хуудас, телевиз, радио, сонин, сэтгүүл болон цахим хуудсаар мэдээлж, олон нийтийг мэдээллээр ханган ажилласан.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 109 байгууллагын тайлан мэдээг нэгтгэн хянав. 2016 онд улсын хэмжээнд ХАСХОМ гаргах нийт 39853 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 39850 мэдүүлэг гаргагч буюу 99.9 хувь нь мэдүүлгээ бүртгүүлсэн байна. Үүнээс хуульд заасан хугацаанд 39848 мэдүүлэг гаргагч бүртгүүлснээс 2 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулсан, 3 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж өгөөгүй бөгөөд зөрчил гаргасан албан тушаалтнуудад Авлигын эсрэг хуулийн дагуу сануулах болон ажлаас халах хүртэлх хариуцлагыг тооцуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргасан мэдүүлэг гаргагч нарын тус бүр 30 хувь нь төрийн захиргааны болон тусгай, 19 хувь нь улс төрийн, 11 хувь нь үйлчилгээний, 1 хувь нь төрийн өндөр албан тушаалын, 9 хувь нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн

удирдах болон бусад ангилалын албан тушаалтан байна. Нийт мэдүүлэг гаргагчийн 26580 буюу 66,7 хувь нь Улаанбаатар хотод, 13270 буюу 33,3 хувь нь орон нутагт байна.

Бүртгүүлбэл зохих мэдүүлэг гаргагчийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн нэгдсэн тайлан, мэдээний дүнгээс үзэхэд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийн талаар мэдүүлсэн 920, ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл гаргасан 26189, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргасан 786, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргасан 5589, давхар ажил эрхлэлтийн талаар танилцуулсан 140, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдээлсэн 15 албан тушаалтан байна.

Нийтийн албан тушаалтнуудын 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэсэн тухай танилцуулга, мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, мөн Авлигатай тэмцэх газрын 122 албан хаагчийн 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, тайлан, бүртгэлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж, хуулийг хэрэгжилтийг ханган ажилласан.

Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад албан тушаалтны томилгоонд хяналт тавьж, нэрсийн жагсаалтыг тухай бүр шинэчлэн гаргав. Нийт 277 албан тушаалтан Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан хугацаанд мэдүүлгээ бүртгүүлэхээс албан үүргээ гүйцэтгэж байгаа нийт 269 албан тушаалтны ХАСХОМ-ийг 100 хувь бүртгэн авсан байна.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өндөр, тэдгээртэй адилтгах албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдээллийг 2 удаа байгууллагын цахим мэдээллийн сүлжээнд, 220 албан тушаалтны 2015 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн №18/927/ дугаарт нийтлүүлж, олон нийтийн www.xасxом.iaас.mn цахим хуудсанд тус тус байршуулсан.

2016 онд УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ээлжит сонгууль болохтой холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороотой хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллав.

Мэдүүлэг гаргагч болон мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг арга зүйн удирдлага, заавар зөвлөмжөөр хангах чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:

Төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагуудын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий 101 албан тушаалтанд, “Мэдүүлэг гаргагчийн үүрэг, мэдүүлгээ шинэчлэн мэдүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр Гадаад хэргийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Монгол банк, Хөдөлмөрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Эрүүгийн цагдаагийн газар, Үндэсний Аудитын газар, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг нийт 103 байгууллагын 6962 байгууллагын 9293 мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад, аймаг, нийслэлийн Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга 44 албан тушаалтанд сургалт зохион байгуулж, ном, гарын авлагаар хангав. Мөн Увс аймгийн 26, Ховд аймгийн 22 эрх бүхий ажилтнуудад онлайн сургалтыг тус тус зохион байгуулсан.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2016 оны үйл ажиллагааны сурталчилгааг нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд байршуулж, иргэд, олон нийтийг танилцах боломжоор хангаж ажиллав.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтын хүрээнд Хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам, Уул уурхайн яам, Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэг, Газрын тосны газар, Гааль, татварын ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх болон Сэлэнгэ аймаг дэх Гаалийн газар болон бусад төрийн 9 байгууллагын 2037 албан тушаалтны 2014, 2015 онуудын 3801 ХАСХОМ-ийг хянасан. Үүнээс 183 албан тушаалтны ХАСХОМ-ийг нарийвчлан шалгуулахаар Хяналт шалгалтын албанд шилжүүлсэн ба холбогдох байгууллагад албан бичгээр зөвлөмж, чиглэл хүргүүлж, зөрчил гаргасан 23 албан тушаалтанд сануулах, 2 албан тушаалтанд цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 30 хувиар бууруулах, 2 албан тушаалтанд ажлаас халах сахилгын шийтгэлийг ногдуулсан бөгөөд 73 албан тушаалтанд нэмэгдэл, урамшуулал хасуулах болон сануулах арга хэмжээг авахуулахаар санал хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.

Хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулаагүй томилогдсон 118 албан тушаалтныг албан тушаалас чөлөөлөх тухай мэдэгдэл хүргүүлэн чөлөөлүүлж, мэдүүлгийг хянуулаагүй зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна. Хянасан ХОМ-ын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал 960 нэгжээр буюу 31.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийн хяналт шалгалтын хүрээнд 2016 онд 302, өмнөх оны үлдэгдэл 29, нийт 331 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгах аас 302 ХАСХОМ-ийг хүлээн авч, 299 мэдүүлгийг шалгаж дууссан ба 32 мэдүүлэг шалгагдаж байна. Хяналт шалгалтын үр дүнг үндэслэн 77 албан тушаалтанд хариуцлага тооцуулсныг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 30 нэгжээр буюу 61 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Шалгасан нийт мэдүүлгийн 254 буюу 84.1 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 29 буюу 9.6 хувийг иргэний гомдол, мэдээллээр, 8 буюу 2.6 хувийг тус газрын Мөрдөн шалгах хэлтсийн шилжүүлснээр, 7 буюу 2.3 хувийг Гүйцэтгэх ажлын хэлтсээс шилжүүлснээр, 4 буюу 1.3 хувийг Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсээс ирүүлснээр хийгдсэн байна.

Албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан нийт 329 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас тайлант хугацаанд 291 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд одоо 38 өргөдөл, гомдол, мэдээлэл ажиллагаанд хянагдаж байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдлыг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 12 буюу 4 хувиар, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол 26 буюу 8.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Хүлээн авсан нийт өргөдөл, гомдол, мэдээллийн 209 буюу 63.5 хувийг иргэнээс, 103 буюу 31.3 хувийг төрийн байгууллага, төрийн өмчит компани, аж ахуйн нэгж, бусад байгууллагаас ирүүлсэн, 17 буюу 5.16% нь нэр хаяг, тодорхойгүй гомдол, мэдээлэл эзэлж байна.

Тус албанд ирүүлсэн өргөдөл гомдол мэдээллийн 63 буюу 19.1 хувийг албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн, 59 буюу 18.0 хувийг албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон бусдад давуу байдал олгосон, 54 буюу 16.4 хувийг албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил гаргаж, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн, 120 буюу 36.4 хувийг ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр, хууль бус үйлдэл гаргасан талаар, 14 буюу 4.3 хувийг албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгуулах, 14 буюу 4.3 хувийг хүнд суртал, ёс зүйн зөрчил шалгуулах, талаар, 5 буюу 1.5 хувийг худалдан авах ажиллагаа

болон тендер сонгон шалгаруулалтын талаар шалгуулах тухай гомдол мэдээлэл эзэлж байна.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 11988 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас 11504 буюу 96.0 хувийг хянан шийдвэрлэсэн, одоо 484 мэдүүлэг хянагдаж байна. Хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, 790 албан тушаалтанд анхааруулж, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр 740 мэдүүлгийг буцаан хүргүүлсэн. Мөн албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг тус газраар хянуулахгүйгээр хууль зөрчин томилсон 132 тушаал, шийдвэрийг хүчингүй болгож, 39 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон тухай дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хүлээн авсан мэдүүлэг 3705, хянан шалгаж хариу өгсөн мэдүүлэг 3385-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан болон хөрөнгө орлогын мэдүүлгийн, өргөдөл, гомдлын хяналт шалгалт, бүрдүүлэлтийн хяналтаар нийт 196 /сануулсан 47, цалин бууруулсан 64, албан тушаал бууруулсан 3, ажлаас халсан 9/ тушаалтанд хариуцлага тооцуулсан байна.

Гурав. Албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиглэлээр

Тайлангийн хугацаанд нийт 985 гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 414 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.3 хувиар буурсан.

Гэмт хэргийн шинжтэй 2015 оны үлдэгдэл 13 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан 414 гомдол, мэдээлэл, нийт 427 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 83 гомдол, мэдээлэл буюу 19.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэн, 274 гомдол, мэдээлэл буюу 64.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж, 49 гомдол, мэдээлэл буюу 11.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж, 21 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 95.1 хувьтай ажиллалаа.

Хянан үзсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг агуулга, холбогдох байгууллага, салбараар нь авч үзвэл нийтийн алба, төрийн албаны үйл ажиллагаанд хамаарах 375 гомдол, мэдээллээс төрийн улс төрийн албанд хамаарах 111, төрийн захиргааны албанд хамаарах 123, төрийн тусгай албанд хамаарах 69, төрийн үйлчилгээний албанд хамаарах 72 гомдол, мэдээлэл, бусад салбарт хамаарах 52 гомдол, мэдээллээс хувийн хэвшл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хамаарах 34, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 4, бусад 14 гомдол, мэдээлэл шалгагдсан.

Хянан үзсэн гомдол, мэдээллийг хүлээн авсан хэлбэрээр нь авч үзвэл, албан бичгээр болон шуудангаар 263, биечлэн 150, факсаар 4, цахим хуудас, шуудангаар 10 гомдол мэдээлэл тус тус иржээ.

Нийт шалгасан гомдол, мэдээллийн 242 буюу 56.7 хувь нь Улаанбаатар хотын, 185 буюу 43.3 хувь нь орон нутгийн харьяалалтай байна.

Тайлангийн хугацаанд хуульд заасан харьяаллын 471 үйлдэл, 459 холбогдогчтой 235 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явууллаа. Мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн 92 буюу 19.5 хувийг хээл хахууль авах, 92 буюу 19.5 хувийг хээл хахууль өгөх, 87 буюу 18.5 хувийг төрийн албан тушаалтан албаны эрх

мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, 28 буюу 5.9 хувийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах, 23 буюу 4.9 хувийг хээл хахуульд зуучлах, 15 буюу 3.2 хувийг төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, 11 буюу 2.3 хувийг мөнгө угаах, 9 буюу 1.9 хувийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, 4 буюу 0.8 хувийг хууль бусаар хөрөнгөжих, 1 буюу 0.2 хувийг төсвийн хөрөнгө зориулалтын бусаар зарцуулах, 109 буюу 23.1 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэргээс 67 буюу нийт шалгасан хэргийн 28.5 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 43 буюу 18.3 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 26 буюу 11.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 40 буюу 17.0 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэж, 13 хэргийг түдгэлзүүлж, одоо 46 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байна.

Мөрдөн шалгах хэлтсийн ажлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөрдөн шалгасан хэрэг 3 нэгжээр буюу 1.3 хувиар буурч, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 12 нэгжээр буюу 21.8 хувиар өсч, хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 7 нэгжээр буюу 14.0 хувиар, үлдэгдэл хэрэг 25.8 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Мөрдөн шалгасан хэргийн 235 хэргийн 176 буюу 74.9 хувийг шийдвэрлэснээс хуулийн анхны хугацаанд 72 буюу 40.9 хувийг шийдвэрлэсэн. Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн 43 хүнд холбогдох 25 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн.

Мөрдөн байцаагч нарын ажлын ачааллыг дунджаар авч үзвэл 1 мөрдөн байцаагч 17.8 гомдол, мэдээлэл, 9.8 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Эрүүгийн хэрэгт 459 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.9 хувиар өссөн, хэргийн холбогдогчдыг албан тушаалын байдлаар нь авч үзвэл төрийн улс төрийн 28 буюу 6.1 хувь, төрийн захиргааны 74 буюу 16.1 хувь, төрийн тусгай 65 буюу 14.2 хувь, төрийн үйлчилгээний 61 буюу 13.3 хувь, төрийн бус байгууллага, төрийн өмчит болон хувийн хэвшлийн ААН-ийн албан тушаалтан 112 буюу 24.4 хувь, энгийн иргэд 119 буюу 25.9 хувийг эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас 37.727.8 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 2.808.9 сая төгрөгийг нөхөн төлүүлж, орон сууц, автомашин, барилга байгууламж, тоног төхөөрөмж зэрэг 11 төрлийн 10 тэрбум 238.9 сая төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө, бэлэн болон дансан дахь 395.4 сая төгрөг, нийт 10 тэрбум 634.3 сая төгрөгийн эд хөрөнгө, бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Хээл хахуулийн хэмжээг авч үзвэл 128.0 сая төгрөгөөр үнэлэгдэх амины орон сууц-1, 309.5 сая төгрөгөөр үнэлэгдэх автомашин-4, 255.0 сая төгрөгөөр үнэлэгдэх зуслангийн байшин-1, 20.0 сая төгрөгөөр үнэлэгдэх автозогсоол-1, 500 мянган төгрөгөөр үнэлэгдэх мал-1, бэлэн мөнгө 4.177.1 сая төгрөг байна.

Дөрөв. Дүгнэлт

- УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр” батлагдав.

- УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2012 оны 5-р тогтоолд нэмэлтээр “ХАСУМ, ХАСХОМ цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай баталгааны маяг”, Мэдүүлгийг хянах, хадгалах, бүртгэх ЭБАТ-аас гаргуулах баталгааны маяг”-ыг 7-р хавсралт болж батлагдлаа.

- АТГ-аас санаачлан НҮБ-аас тунхагласан “Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг тохиолдуулан “Авлига ба хүний эрх” бага хурлыг УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Гадаад харилцааны яам, Хууль зүй, Дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулав.

- Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтыг механизмыг бүрдүүлэх чиг үүрэг бүхий “Олон нийтийн дэд зөвлөл” үйл ажиллагаа явуулах эхлэлийг тавьлаа.

- Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 85 дугаар тогтоолоор “Стратеги судлалын хүрээлэн”-ийн байрлаж байсан байрыг тус газрын үндсэн хөрөнгөд шилжүүлэн авч иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, бизнесийн төлөөлөлд авлигатай тэмцэх хууль тогтоомжийн талаар эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, зөвлөмж өгөх, мэдээллийг чөлөөтэй нээлттэй өгөх замаар Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах зорилго бүхий “Олон нийтийн төв”-ийг байгуулж, үйл ажиллагаа эхлүүлэхэд бэлэн болгоод байна.

- Байгууллагын цахим хуудасны үзэмж, багтаамж нэмэгдэж, санд шинээр нэмэгдэн орж буй мэдээ, мэдээллийн хэл найруулга, чанарын агуулга сайжирч, баяжилт тогтмолжсон, нийгмийн мэдээллийн сүлжээ */facebook, twitter, youtube/-г* түлхүү ашиглаж, хандалт ба эргэх холбоо нэмэгдсэн.

- Байгууллагын бичиг хэргийн ажил программчлагдсанаар албан бичгийн эргэлтэд тавих хяналтад зохих ахиц гарсан байна.

- Төрийн байгууллагын мэдээллийн санг ашиглах хүрээнд Газрын харилцаа, Геодези, зураг зүйн газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн газрын хуулийн этгээд, тээврийн хэрэгслийн лавлагааг албан хэрэгцээнд ашигладаг болсон.

- ХАСХОМ-ийн цахим системийн үйл ажиллагааг боловсронгуй болгосноор судалгаа, дүн шинжилгээ хийх, мэдээ, тайланг цаг алдалгүй гаргах, хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь оновчтой үр дүнтэй болж, албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн орлого, хөрөнгийн өсөлт, бууралтыг хянан үзэх боломжтой байдлаар ХАСХОМ-ийн цахим системийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлууд хийгдсэн байна.